ХОВД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

84140 Ховд, Ховд аймаг
Утас/Факс: (+976) 70432506
E-mail: Khovdzdtg@khovd.gov.mn

2020.09.13 № 1/619

танай ________ -ны № ________ -т

## ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Ш.НОХОЙЖАВ ТАНАА

Манай зарлаж байгаа Жаргалант сумын Буянт багт улсын төсвөөр баригдах 240 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих 2 тэрбум 600 сая төгрөгийн өртөг бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны ажлын явцтай холбоотой гомдол мэдээлэл удаа дараа ирсэн байна.

Хууль журмын дагуу хянаж үнэлгээний хороог дахин хуралдуулж, хамгийн гол нь аж ахуйн нэгж компаниудад адил тэгш боломж олгох тал дээр онцгой анхаарч хууль журамд нийцэж байвал 7-10 хоног сунгаж болно.

Мөн 9 дүгээр сарын 1 гэхэд барилгын ажил хүлээн авах боломж бүрдэх ёстой гэдгийг анхаарч танай байгууллага үнэлгээний хороодыг хянаж, зөвлөж ажиллах үндсэн үүргээ биелүүлж 2020 оны худалдан авах бүхий л төсөл арга хэмжээг шударга, ил тод зохион байгуулж, худалдан авах ажиллагаа бүхнийг сурталчлан иргэд, олон нийтэд тайлагнаж ажиллахыг үүрэг болгож байна.

ДАРГА Д.ЭНХБОЛД

Үнэлгээний хороог хуралдуулж хуулийн хугацаанд шийдвэрлэх.
Ш.

4/13

2019 А/5 Ch

**Baganat-Ord**
**LLC**

*Ховд аймаг Жаргалант сум*
*Бичигт баг, 7-р гудамж 24 тоот*
*Утас: 99081236, 99066516*
*И-Мэйл: Baganatord83@gmail.com*

2020.04.13 №01/175

Танай ____________-ны ____________

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЭНХБОЛД ТАНАА**

*Хүсэлт гаргах нь:*

Ховд аймгийн худалдан авах ажиллагааны газраас зарласан Цэцэрлэгийн барилга 240 ор /Ховд, Жаргалант сум, 9-р цэцэрлэг/ тендер шалгаруулалтын материал 2020 оны 03 сарын 17 өдөр www.tender.gov.mn-д тавигдсан болович тендерийн бичиг баримт нь 2020 оны 04-р сарын 07 өдөр, 2020 оны 04-р сарын 09 өдөр удаа дараа хууль бусаар өөрчлөгдсөн байна.

2020 оны 04-р сарын 07 өдөр ТӨӨЗ 5,3(д) заасан түргэн хөрвөх хөрөнгө нь Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт гэсэн заалтын тайлбар хэсэгт, Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох зээлийн хорооны батлагдсан шийдвэр хавсаргах шаардлагатай гэж, 2020 оны 04-р сарын 09 өдөр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээл авах зээлийн хэмжээ 780,000,000 сая төгрөг буюу тендер санал болгож буй төсөв өртгийн 30% байх гэснийг 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөг гэж өөрчилсөн нь хэн нэгэн аж ахуй нэгжид хэт их давуу эрх үүсгэж бусад компани аж ахуй нэгжүүдийн өрсөлдөх чадварыг хязгаарлаж байна гэж үзэж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1, 22.1, 50.1.1-д тус тус заагдсан заалтуудыг зөрчиж байна.

Дээрхи байдлаас үзэхэд аймгийн орон нутгийн өмчийн газар болон холбогдох газруудаас гаргасан үнэлгээний хороо нь өөрийн эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэж дээрхи хуулийн ил тод, нээлттэй шударга өрсөлдөх зарчимыг зөрчиж бусдад давуу эрх олгох гэсэн санаархал, / аливаа нэгэн ажилд банкны тодорхойлолтыг судлан үзэж шийдвэрлэх боломжтой гэдэг дүгнэлтийг үндэслэн үнэлгээний хорооны шийдвэрт харгалзан үздэг болохоос биш шийдвэр нь гараагүй байгаа ажилд ямар зээлийн хорооны дүгнэлт шаардаж байгаа зэрэг / гаргаж байгаад манай компани болон бусад аж ахуй нэгжүүд илт эсэргүүцэж байгаа тул уг ажлын үнэлгээний хороог дахин байгуулж өгнө үү.

ЗАХИРАЛ Г.БАЯНМӨНХ

Үнэлгээний хорооны дарга нарийн бичиг нарт
Хууль ёсны хүрээнд шийдвэрлэх
Ш.Мөнх-Од

Судлан. Холбогдох арга хэмжээг дэмжлэг авах
13/13

**ХОВД АЙМАГ**
**ЖАРГАЛАНТ СУМЫН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТӨЛӨӨЛӨГЧ БАТМӨНХИЙН ТУУЛАЙТУЛГА**

2020 оны 04 сарын 09 өдөр Дугаар 08 Ховд

# ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Б.ДҮГЭРЖАВ

## ТАНАА

Ховд аймгийн худалдан авах ажиллагааны газраас зарласан Цэцэрлэгийн барилга, 240 ор /Ховд, Жаргалант сум, 9 дүгээр цэцэрлэг/ тендер шалгаруулалтын тендерийн материал 2020 оны 03 сарын 17-ны өдөр **tender.gov.mn**-д тавигдсан.

Дээрх тендерийн бичиг баримт нь дараах байдлаар удаа дараа хууль бусаар өөрчлөгдлөө.

2020 оны 04-р сарын 07-ны өдөр ТӨӨЗ 5,3 (д) заасан түргэн хөрвөх хөрөнгийн "Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт" гэсэн заалт нь "Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох зээлийн хорооны шийдвэр хавсаргах шаардлагатай" гэж, 2020 оны 04-р сарын 09-ны өдөр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн дүн 780,000,000 төгрөг байсныг 1,000,000,000 төгрөг гэж өөрчилсөн нь хэн нэгэн компани, аж ахуй нэгжид хэт давуу тал бий болгож бусад компани аж ахуй нэгжүүдийн өрсөлдөх боломжийг боомилж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн

6.1-д заасан худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална,

22.1-д заасан захиалагч тендерийн баримт бичгийг тендерийн урилга нийтлэгдэх өдрөөс өмнө бэлэн болгосон байх үүрэгтэй,

50.1.1-д заасан шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх,

50.1.5-д заасан тендерт оролцогч нь хээл хахууль санал болгох, дарамт шахалт үзүүлэх зэргээр тендер шалгаруулалтын дүнд нөлөөлөхийг оролдвол энэ тухай өөрийн шууд харьяалан удирдах албан тушаалтан, хууль, хяналтын байгууллагад нэн даруй мэдэгдэх зэрэг заалтуудыг илтэээр зөрчиж байна.

Н. Ганзориг (ХБХ)-т ([illegible])
[illegible]

Мөн Монгол улсын их хурлын гишүүн Сандагийн Бямбацогтын 2020 оны 3-р сарын 04-ны өдрийн 1942 тоот дугаартай Тендер шалгаруулалтыг шилэн болгох тухай албан тоот Ховд аймгийн засаг дарга Б.Дугэржав танд ирүүлсэн билээ.

Тус албан тоотод Ховд аймгийг шилэн тендер, хуудуугүй худалдан авалт зохион байгуулдаг жишиг аймаг болгохын төлөө ажилдаа зэний ёсоор хандахыг танаас хүссэн байдаг.

Иймд тус тендерийн хуудуутай үйл ажиллагаатай өөрийн биеэр танилцаж хуулийн дагуу зохион байгуулах, шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлж өгөхийг хүсье.

Холбогдох материалуудыг хавсаргав.

Хувийг Улсын Их Хурлын С.Бямбацогт гишүүнд

ЖАРГАЛАНТ СУМЫН ИТХ
ТӨЛӨӨЛӨГЧ: Б. ТУУЛАЙТУЛГА

..........08.......... тоот албан тоотын хавсралт

1. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсан заалтыг харьцуулалтаар харуулав.

| Заалт | 2020 оны 03 сарын 17-нд тавигдсан бичиг баримт | 2020 оны 04 сарын 07-нд өөрчлөгдсөн бичиг баримт | 2020 оны 04 сарын 09-нд өөрчлөгдсөн бичиг баримт |
|---|---|---|---|
| ТӨӨЗ 5.3 (а) | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн:<br>- 780 000 000 төгрөгөөс багагүй байх<br>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлно.<br>1. Байгууллагын дансны үлдэгдэл / харилцагч банкны/<br>2. Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт<br>/Судлаж үзээд зээл олгох боломжтой албан бичгийг үнэлгээнд тооцохгүй болно./ | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн:<br>- 780 000 000 төгрөгөөс багагүй байх<br>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлно.<br>1. Байгууллагын дансны үлдэгдэл / харилцагч банкны/<br>2. Арилжааны банкны судлагдсан зээлийн авч зээлийн хорооны шийдвэр хавсаргах шаардлагатай<br>/Судлаж үзээд зээл олгох боломжтой албан бичгийг үнэлгээнд тооцохгүй болно./ | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн:<br>- 1 000 000 000 төгрөгөөс багагүй байх<br>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлно.<br>1. Байгууллагын дансны үлдэгдэл / харилцагч банкны/<br>2. Арилжааны банкны судлагдсан зээлийн авч зээлийн хорооны шийдвэр хавсаргах шаардлагатай<br>/Судлаж үзээд зээл олгох боломжтой албан бичгийг үнэлгээнд тооцохгүй болно./ |

2. Дээр дурьдагдсан өөрчлөлт нь хууль зөрчсөн мөн өрсөлдөөнийг боомилсон, хэн нэгэн компани аж ахуй нэгжид хэт давуу талыг бий болгож буй талаарх тайлбар:
   - Тендер нээгдэхэд 7 хоног үлдсэн байсан ба энэ хугацаанд 1,000,000,000 төгрөгийн зээлийг шуурхай шийдвэрлэх боломжтой банк, банк бус санхүүгийн байгууллага байхгүй байна. Арилжааны банкуудын журманд болон нийтэд мэдээлэсэн нь бизнесийн зээлийг 14 хоногт шийдвэрлэнэ гэсэн байдаг.
   - Хугацааг нь тулгаж мөн банк санхүүгийн байгууллагаас зээл шийдвэрлүүлэх боломжийг хааж өөрчлөлт нь зориудаар хэн нэгэн өөртөө давуу тал бий болгохоор Худалдан авах ажиллагааны газарт, түүний удирдлага, ажилтнуудад хууль бусаар нөлөөлсөн гэж харагдаж байна.

| | |
|---|---|
| ТОӨЗ 5.3 (б) | Ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: ***Сүүлийн 2 жил буюу / 2018, 2019 он/***<br><br>***Уг ажлын гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комисс акт, захиалагчийн тодорхойлолт хавсаргана.***<br><br>***Дуусаагүй ажлын гүйцэтгэл 80%-аас багагүй байхыг нотолсон баримт захиалагчийн тодорхойлолтыг тендерт ирүүлнэ.*** |
| ТОӨЗ 5.3 (в) | Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд:<br><br>кран<br>ковш<br>Угсралтын агрегат<br>Түлгүүр ачигч<br>Төмрийн цахилгаан хайч<br>Хийн цохилтот нягтруулагч<br>Хар тос чанадаг тогоо<br>Цахилгаан гагнуурын агрегат<br>Цахилгаан өрөм<br>Экскаватор<br>Бетон зуурмагийн насос<br>Ацетилений генератор<br>Гагнуурын аппарат<br>Гүний доргиур<br>Зуурмаг зуурагч<br>Зуурмагийн хөнөг<br>Зөөврийн машин<br>Компрессор<br>Насос<br>Өндөр бүтээмжтэй нураах алх<br>Үйлчилгээний машин<br>Ачааны машин<br><br>***Дээрхи тоног төхөөрөмжүүдээс 18 багаж тоног төхөөрөмж нь өөрийн байх холобгдох баримтыг хавсаргах /*** |
| ТОӨЗ 5.3 (г) | Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: ***3 жил***<br><br>Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх хугацаа: ***3 жил*** |
| ТОӨЗ 5.3 (д) | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн[7] нийт дүн:<br>- ***780 000 000 төгрөгнөөс багагүй байх***<br><br>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийтт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлно.<br>1. **Байгууллагын дансны үлдэгдэл / харилцагч банкины/**<br>2. **Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт** / судлаж үзээд зээл олгох боломжтой албан бичгийг үнэлгээнд тооцохгүй болно./ |

[7] Авах боломжтой зээл гэдэгт тухайн баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.

| | |
|---|---|
| ТОӨЗ 5.3 (б) | Ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: ***Сүүлийн 2 жил буюу / 2018, 2019 он/***<br><br>***Уг ажлын гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комисс акт, захиалагчийн тодорхойлолт хавсаргана.***<br><br>***Дуусаагүй ажлын гүйцэтгэл 80%-аас багагүй байхыг нотолсон баримт захиалагчийн тодорхойлолтыг тендерт ирүүлнэ.*** |
| ТОӨЗ 5.3 (в) | Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд<br><br>кран<br>ковш<br>Үсрэлтын агрегат<br>Тулгуур ачигч<br>Төмрийн цахилгаан хайч<br>Хийн цохилтот нягтруулагч<br>Хар тос чанадаг тогоо<br>Цахилгаан гагнуурын агрегат<br>Цахилгаан өрөм<br>Экскаватор<br>Бетон зуурмагийн насос<br>Ацетиленийн генератор<br>Гагнуурын аппарат<br>Гүний доргиур<br>Зуурмаг зуурагч<br>Зуурмагийн хөнөг<br>Зээрийн машин<br>Компрессор<br>Насос<br>Өндөр бүтээмжтэй нураах алх<br>Үйлчилгээний машин<br>Ачааны машин<br><br>***Дээрхи тоног төхөөрөмжүүдээс 18 багаж тоног төхөөрөмж нь өөрийн байх холобгдох баримтыг хавсаргах /*** |
| ТОӨЗ 5.3 (г) | Ерөнхий инженер нь барилгын инженер байх гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: ***3 жил***<br><br>Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх хугацаа: ***3 жил*** |
| ТОӨЗ 5.3 (д) | Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн[1] нийт дүн:<br>- ***780 000 000 төгрөгнөөс багагүй байх***<br>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийтт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлно.<br>1. **Байгууллагын дансны үлдэгдэл / харилцагч банкины/**<br>2. **Арилжааны банкны судлагдсан зээлийн авч зээлийн хорооны шийдвэр хавсаргах шаардлагатай/** судлаж үзээд зээл олгох боломжтой албан бичгийг үнэлгээнд тооцохгүй болно./ |

[1] Авах боломжтой зээл гэдэгт зээлийн баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл хэрэг байж болно.

<table>
<tr><td>ТӨЗ 5.3 (б)</td><td>Ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа Сүүлийн 2 жил буюу / 2018, 2019 он/<br><br>Уг ажлын гэрээ, ажил хүлээлгэж өгсөн улсын комисс акт, захиалагчийн тодорхойлолт хавсаргана.<br><br>Дуусаагүй ажлын гүйцэтгэл 100% захиалагч буюу ашиглагч байгууллагын тодорхойлолт тодорхойлолтыг тендерт ирүүлнэ.</td></tr>
<tr><td>ТӨЗ 5.3 (в)</td><td>Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд:<br>
<table>
<tr><td>кран</td></tr>
<tr><td>ковш</td></tr>
<tr><td>Угсралтын агрегат</td></tr>
<tr><td>Тулгуур ачигч</td></tr>
<tr><td>Төмрийн цахилгаан хайч</td></tr>
<tr><td>Хийн цохилтот нягтруулагч</td></tr>
<tr><td>Хар тос чанадаг тогоо</td></tr>
<tr><td>Цахилгаан гагнуурын агрегат</td></tr>
<tr><td>Цахилгаан өрөм</td></tr>
<tr><td>Экскаватор</td></tr>
<tr><td>Бетон зуурмагийн насос</td></tr>
<tr><td>Ацетиленийн генератор</td></tr>
<tr><td>Гагнуурын аппарат</td></tr>
<tr><td>Гүний доргиур</td></tr>
<tr><td>Зуурмаг зуурагч</td></tr>
<tr><td>Зуурмагийн хөнөг</td></tr>
<tr><td>Зөөврийн машин</td></tr>
<tr><td>Компрессор</td></tr>
<tr><td>Насос</td></tr>
<tr><td>Өндөр бүтээмжтэй нураах алх</td></tr>
<tr><td>Үйлчилгээний машин</td></tr>
<tr><td>Ачааны машин</td></tr>
</table>
<br>Дээрхи тоног төхөөрөмжүүдээс 18 багаж тоног төхөөрөмж нь өөрийн байх холбогдох баримтыг хавсаргах /</td></tr>
<tr><td>ТӨЗ 5.3 (г)</td><td>Ерөнхий инженер нь барилгын инженер байх гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа: 3 жил<br><br>Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх хугацаа: 3 жил</td></tr>
<tr><td>ТӨЗ 5.3 (д)</td><td>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн[7] нийт дүн:<br>- 1 000 000 000 төгрөгнөөс багагүй байх<br>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийтт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр тодорхойлно.<br>1. Байгууллагын дансны үлдэгдэл / харилцагч банкины/<br>2. Арилжааны банкны судлагдсан зээлийн авч зээлийн хорооны шийдвэр хавсаргах шаардлагатай/ судлаж үзээд зээл олгох боломжтой албан бичгийг үнэлгээнд тооцохгүй болно./</td></tr>
</table>

7 Авах боломжтой зээл гэдэгт тухайн баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Б.ДУГЭРЖАВ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Сандагийн БЯМБАЦОГТ

2020.03.04 № 1442

таны ______________ -ны №______________ -т

Тендер шалгаруулалтыг
шилэн болгох тухай

Танд энэ өдрийн мэнд хүргэе. Нийгэмд шударга ёс тогтоох ажил тендертэй холбоотой аливаа будлиан, авлига, хээл хахуулийг устгахаас эхлэх ёстой.

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бүхий л үйл ажиллагааг 100 хувь иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулахыг ард түмэн хүсэж хүлээж байна. Ингэж байж шилэн тендер бий болно.

Цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх, хүнд суртал, авлигыг халах Шилэн тендерийн энэ тогтолцоог бий болгоход Ховд аймаг анхдагч нь байхыг Ховдчууд бүгд хүсч байгаа гэдэгт итгэлтэй байна.

Бүх тендер шалгаруулалт шил мэт тунгалаг, олон нийтэд ил тод байж гэмээнэ төрд, аймаг орон нутгийнхаа удирдлагад итгэх ард иргэдийн итгэл нэмэгдэнэ.

Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшлийн төлөөлөл, тухайн нутаг дэвсгэрийн иргэд оролцож байж тендер шалгаруулалт цэвэр тунгалаг болно.

Худалдан авах ажиллагааг ил тод, тунгалаг болгож байж түүнийг дагасан хулгайг илчилж, хуулийн хариуцлага тооцох боломж бүрдэнэ.

2020 онд Ховд аймаг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын хэмжээгээрээ 21 аймгаас Хэнтий аймгийн дараа улсдаа эхний 2-т орж байна. Тиймээс хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил нэг бүрийг хамгийн үр дүнтэй, чанартай хийж, тендер шалгаруулалтыг ил тод зохион байгуулах ажлыг энэ оны 3 дугаар сараас эхлүүлж, цаашид хэвшил болгох зоригтой шийдвэр гаргаасай гэж танд хандаж байна.

Хууль зөрчиж тендер авсан, төр болон иргэдийг хуурч тендерийн хулгай хийсэн аливаа зүй бус үйлдлийн талаар мэдээлэл өгсөн иргэнийг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу урамшуулж байх нь энэ ажилд том хөшүүрэг болно.

Ховд аймгийг шилэн тендер, хүүдүүгүй худалдан авалт зохион байгуулдаг жишиг аймаг болгохын төлөө ажилдаа ээлтэй өсөөр хандахыг танаас хүсье.

Хүндэтгэсэн

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ

00000273